

ДОТООД АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, 2024 оны 214 дүгээр тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны 2017 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Хууль зүйн яам, түүний харьяа агентлаг, байгууллагын дотоод аудитын журам”-ыг үндэслэн байгууллагын даргын 01-08/08 дугаар удирдамжийн дагуу 08 дугаар сарын 25-наас 29-ний өдрүүдэд танай газрын энэ оны 01-07 дугаар сарын санхүүгийн үйл ажиллагаа, батлан гаргасан тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд санхүү болон нийцлийн аудитын хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Тус хяналт шалгалтаар санхүүгийн болон батлан гаргасан тушаал, бусад байгууллагатай байгуулсан гэрээний хэрэгжилтийн чиглэлээр ноцтой зөрчил илрээгүй бөгөөд илэрсэн дутагдал нь засагдах боломжтой тул цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1.1. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах” гэж заасныг мөрдөж ажиллах;

1.2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг мөрдөж ажиллах;

1.3. Баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, зөв бичих дүрэм, стандартад заасан шаардлагын дагуу зохион бүрдүүлж, түүний үнэн зөв, албан ёсны хүчинтэй байдлыг ханган боловсруулж ажиллах зэрэг болно.

ДОТООД АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны 2017 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Хууль зүйн яам, түүний харьяа агентлаг, байгууллагын дотоод аудитын журам”-ыг үндэслэн байгууллагын даргын 01-08/09 дүгээр удирдамжийн дагуу 09 дүгээр сарын 15-наас 19-ний өдрүүдэд танай хэлтсийн энэ оны 01-08 дугаар сарын санхүүгийн үйл ажиллагааны хэрэгжилтэд аудитын хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Тус хяналт шалгалтаар санхүүгийн чиглэлээр ноцтой зөрчил илрээгүй бөгөөд илэрсэн дутагдал нь засагдах боломжтой тул цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1.1. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах” гэж заасныг мөрдөж ажиллах;

1.2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцүүлэн анхан шатны баримтыг хөтлөх;

1.3. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг мөрдөж ажиллах;

--oo0oo--

ДОТООД АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, 2024 оны 214 дүгээр тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны 2017 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Хууль зүйн яам, түүний харьяа агентлаг, байгууллагын дотоод аудитын журам”-ыг үндэслэн байгууллагын даргын 05 дугаар сарын 20-ны өдрийн 01-08/04 дугаар удирдамжийн дагуу 05 дугаар сарын 28-ны өдрөөс 06 дугаар сарын 03-ны өдрүүдэд танай газрын энэ онд 01-05 дугаар сарын санхүүгийн үйл ажиллагаа, батлан гаргасан тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд санхүү болон нийцлийн аудитыг хийж гүйцэтгэв.

Тус шалгалтаар санхүүгийн болон батлан гаргасан тушаал, бусад байгууллагатай байгуулсан гэрээний хэрэгжилтийн чиглэлээр ноцтой зөрчил илрээгүй бөгөөд илэрсэн дутагдал нь засагдах боломжтой тул цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1.1 Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах” гэж заасныг мөрдөх;

1.2 Хяналт, шалгалтын байгууллагаас хүргүүлсэн дүгнэлт, зөвлөмж, төв байгууллагын хийсэн дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг тухай бүр ханган ажиллах;

1.3 Баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, зөв бичих дүрэм, стандартад заасан шаардлагын дагуу зохион бүрдүүлж, түүний үнэн зөв, албан ёсны хүчинтэй байдлыг ханган боловсруулж ажиллах зэрэг болно.

--00000--